

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Байгууллагын өмч хөрөнгийн талаар.....	10
3.2	Түрээсийн төлбөрийн талаар	11
3.3	Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар	11
3.4	Анхан шатны баримтын бүрдэлийн талаар.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/265
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл, тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн захирал Г.Номин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Интер аудит” ХХК-ийн захирал П.Дарамрагчаа, аудитор Д.Базаргарам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Интер аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №01/12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь Монгол улсын төр, засгаас байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц, баялгийг зөв зохистой ашиглах талаар гаргасан бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх, сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээ явуулах, энэ талаарх олон улсын хурал, зөвлөгөөн, сургалт семинар явуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчин, цэнгэг усны чиглэлээр сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээний ажил явуулах

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын САГ-2019/369/СТА-ТШЗ

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Тайлант онд Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн №207 дугаар тушаалын санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлгээ хийгдсэн.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “асолус” програм хангамж ашигладаг байна.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг САГ-2019/369/СТА-ТШЗ

судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудитор тогтоосон материаллаг байдлыг тусгайлсан ажил гүйлгээ, дансанд тодруулгуудад хамааралтай, эсвэл эрсдэл нь бүхэлдээ санхүүгийн тайлантай хамааралтай эсэхийг авч үзсэнтэй холбоотой юм.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны нийт зардал 4,645.2 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 9,290.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотойгоор зардлын дүн өссөнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	12,156.3	
	Дүн	4	12,156.3	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад төлбөрийн акт тогтоосон, албан шаардлага өгсөн, сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн, хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн зэрэг асуудал гараагүй бөгөөд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулсан.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 299,744.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 289,591.8 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа ба 10,152.8 мянган төгрөг буюу 3.4 хувийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Үүний 6,426.6 мянган төгрөг нь орон тоо дутуу ажилласан цалингийн зардлын хэмнэлт, 683.0 мянган төгрөг нь хэрэглээгээр төлдөг тогтмол зардлын хэмнэлт, 171.6 мянган төгрөг нь ашиглалтаар төлдөг шуудан холбоо, интернетийн зардлын хэмнэлт, 2,867.6 мянган төгрөг нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас тус тус хэмнэгдсэн.

Мөн 2018 онд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь сургалтын танхим ашиглуулсан төлбөр 14,530.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын өмч хөрөнгийн талаар

Илрүүлэлт:

Байгууллага өөрийн хөрөнгийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлээгүй байгаа нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн дүрмийн 5.1-д “Үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу эрх эдэлж, үүрэг хүлээх нөхцөл бүрдэхгүй байна.

Эрсдэл:

Байгууллагын өөрийн хөрөнгө улсын бүртгэлийн гэрчилгээгээр баталгаажихгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А208 дугаар тушаал “Хуулийн этгээд түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн дүнг бичүүлж, баталгаажуулах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.2 Түрээсийн төлбөрийн талаар

Илрүүлэлт:

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь “Монголын байгаль орчны иргэний зөвлөл”, “Байгаль, зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг” төрийн бус байгууллагуудад өөрийн байрыг түрээслэхдээ дараах зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын дагуу гэрээ байгуулаагүй.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт түрээсийн орлого төвлөрүүлээгүй.

Эрсдэл:

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоолуудыг тус тус зөрчиж түрээсийн орлого төвлөрүүлээгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Түрээсийн гэрээгээр байрлаж буй төрийн бус байгууллагуудыг Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоол мөн 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”, 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 293 дугаар “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах.

Мөн Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам”-ын 2.17-д “Төрийн өөрийн өмчийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төвлөрүүлж, улсын төвлөрсөн төсөвт оруулах” гэж заасныг дагаж мөрдөх.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.3 Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар

Илрүүлэлт:

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийх явцад 5-6 жилийн өмнө бүртгэлд авсан ашиглагдахгүй байгаа 6,168.3 мянган төгрөгийн үнэлгээтэй кафетерийн зориулалт бүхий үндсэн хөрөнгүүд байна.

Эрсдэл:

Ашиглагдахгүй байгаа хөрөнгийн үнэ цэнэ буурах, ашиглалтын үр өгөөж буурах, дутагдах, шамшигдах, үргүй зардал бий болох.

Өгсөн зөвлөмж:

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн ашиглагдахгүй байгаа кафетерийн үндсэн хөрөнгүүдийг холбогдох тушаал шийдвэрийг гаргуулж, хэрэгцээтэй газар нь худалдан борлуулах, орлогыг нэмэгдүүлэх, шилжүүлэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгүүдийн үлдэгдлийг багасгах, эсвэл байгууллагын менежментийн төлөвлөгөөнд оруулж цаашид ашиглах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.4 Анхан шатны баримтын бүрдэлийн талаар

Илрүүлэлт:

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь 5,988.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийсэн.

Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтын бүрдэлийг хэрэгжүүлэхгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын бүрдэлийг ханган ажиллаж, шат шатны хяналтыг хэрэгжүүлэх.

(Гэрээгээр ажил гүйцэтгэж буй ААН-үүдийн гэрчилгээ, дүрмийн хуулбарыг заавал авч байх, баримтуудад засвар оруулахгүй байх, гарын үсэг, тамга зэргийг сайн нягталж байх)

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,558,871.20</u>	<u>58,760,962.97</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
АВЛАГА	1,450,000.00	82,556.10
Бусад авлага	1,450,000.00	82,556.10
Байгууллагаас авах авлага	1,450,000.00	82,556.10
УРЬДЧИЛГАА	00.00	00.00
БАРАА МАТЕРИАЛ	55,108,871.20	58,678,406.87
Түүхий эд материал	49,060,737.20	47,406,018.20
Тусгай зориулалттай материал	49,060,737.20	47,406,018.20
Хангамжийн материал	6,048,134.00	11,272,388.67
Бичиг хэргийн материал	1,105,180.00	399,087.00
Аж ахуйн материал	917,605.00	120,573.67
Түлш, шатах тослох материал	187,000.00	00.00
Барилгын засварын материал	493,850.00	2,086,100.00
Бусад хангамжийн материал	3,344,499.00	8,666,628.00
НӨӨЦИЙН БАРАА	00.00	00.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,060,470,721.66</u>	<u>3,359,032,836.02</u>
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,060,470,721.66	3,359,032,836.02
Биет хөрөнгө	7,060,305,721.66	3,358,927,836.02
Барилга, байгууламж, орон сууц	7,191,400,841.00	3,213,032,846.00
Хуримтлагдсан элэгдэл	-472,471,215.36	-19,600,678.69
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,738,675,190.00	1,738,675,190.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,588,778,557.38	-1,736,492,414.49
Тавилга, аж ахуйн эд хогшил	243,754,840.00	243,754,840.00
Хуримтлагдсан элэгдэл	-118,548,766.60	-148,165,336.80
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	57,395,400.00	58,845,400.00
Ном	8,877,990.00	8,877,990.00
Биет бус хөрөнгө	165,000.00	105,000.00
Програм хангамж	1,675,000.00	1,675,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,510,000.00	-1,570,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,117,029,592.86</u>	<u>3,417,793,798.99</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,117,029,592.86</u>	<u>3,417,793,798.99</u>
Засгийн газрын хувь оролцоо	7,117,029,592.86	3,417,793,798.99
Хуримтлагдсан үр дүн	7,114,617,592.86	3,397,394,842.70
Өмнөх үеийн үр дүн	7,114,617,592.86	7,114,617,592.86
Тайлант үеийн үр дүн	00.00	-3,717,222,750.16
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	17,986,956.29
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	2,412,000.00	2,412,000.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,117,029,592.86</u>	<u>3,417,793,798.99</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	432,794,584.28	928,007,267.00
ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,895,824.28	51,241,667.00
Нийтлэг татварын бус орлого	5,895,824.28	42,780,056.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	5,895,824.28	42,780,056.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,055,000.00	00.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,840,824.28	42,780,056.00
Зээлийн орлого	00.00	8,461,611.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,898,760.00	876,765,600.00
Улсын төвлөрсөн төсвөөс	303,843,900.00	299,744,600.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	303,843,900.00	299,744,600.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	123,054,860.00	577,021,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	109,491,860.00	228,321,600.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	334,169,400.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,563,000.00	14,530,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	975,334,300.65	1,182,828,567.46
УРСГАЛ ЗАРДАЛ	975,334,300.65	1,182,828,567.46
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937,514,158.52	1,149,684,155.63
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,647,064.70	202,639,486.51
Үндсэн цалин	146,770,900.00	164,936,374.99
Нэмэгдэл	31,724,464.70	16,817,111.52
Унаа хоолны хөнгөлөлт	17,151,700.00	20,886,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,067,600.00	25,104,399.47
Тэтгэврийн даатгал	14,043,100.00	16,978,603.73
Тэтгэмжийн даатгал	1,604,900.00	2,122,325.47
ҮОМШӨ-ний даатгал	2,006,100.00	1,482,194.25
Ажилгүйдлийн даатгал	401,200.00	411,025.09
Эрүүл мэндийн даатгал	4,012,300.00	4,110,250.93
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,092,592.00	34,893,433.00
Гэрэл, цахилгаан	16,949,395.00	19,578,845.00
Түлш, халаалт	9,042,006.00	11,121,333.00
Цэвэр, бохир ус	4,101,191.00	4,193,255.00
Хангамж, бараа материалын зардал	31,871,055.05	18,369,671.42
Бичиг хэрэг	7,237,513.08	8,052,323.00
Тээвэр, шатахуун	8,551,360.00	5,703,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,353,748.17	3,407,567.09
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,949,633.80	1,206,781.33

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материал акталсны зардал	3,778,800.00	00.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,483,240.00	1,327,298.00
Урсгал засвар	1,483,240.00	1,327,298.00
Томилолт, зочны зардал	1,815,600.00	2,164,500.00
Дотоод албан томилолт	1,815,600.00	2,164,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,912,878.60	287,101,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,412,878.60	285,601,800.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	586,624,128.17	578,083,567.23
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.00	00.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	85,547,024.40	276,830,119.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	501,067,103.77	301,253,448.23
Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,820,142.13	33,144,411.83
Бусад урсгал шилжүүлэг	4,329,000.00	00.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,329,000.00	00.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,491,142.13	33,144,411.83
Төвлөрүүлэх шилжүүлэг	33,491,142.13	33,144,411.83
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-542,539,716.37</u>	<u>-254,821,300.46</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,212,610.00	3,462,401,449.70
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,212,610.00	00.00
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	3,462,401,449.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-4,212,610.00	-3,462,401,449.70
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-546,752,326.37</u>	<u>-3,717,222,750.16</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>462,339,260.00</u>	<u>885,227,211.00</u>
ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,055,000.00	8,461,611.00
Нийтлэг татварын бус орлого	2,055,000.00	00.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,055,000.00	00.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,055,000.00	00.00
Зээлийн орлого	00.00	8,461,611.00
Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	460,284,260.00	876,765,600.00
Улсын төвлөрсөн төсвөөс	303,843,900.00	299,744,600.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	303,843,900.00	299,744,600.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	156,440,360.00	577,021,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	142,877,360.00	228,321,600.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	334,169,400.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,563,000.00	14,530,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>462,349,260.00</u>	<u>885,227,211.00</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	462,349,260.00	885,227,211.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,529,117.87	852,082,799.17
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,647,064.70	200,885,115.03
Үндсэн цалин	146,770,900.00	173,103,715.03
Нэмэгдэл	31,724,464.70	10,629,700.00
Унаа хоолны хөнгөлөлт	17,151,700.00	17,151,700.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,067,600.00	24,877,400.00
Тэтгэврийн даатгал	14,043,100.00	16,584,900.00
Тэтгэмжийн даатгал	1,604,900.00	2,073,200.00
ҮОМШӨ-ний даатгал	2,006,100.00	1,658,500.00
Ажилгүйдлийн даатгал	401,200.00	414,600.00
Эрүүл мэндийн даатгал	4,012,300.00	4,146,200.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,301,592.00	34,893,433.00
Гэрэл, цахилгаан	16,949,395.00	19,578,845.00
Түлш, халаалт	9,042,006.00	11,121,333.00
Цэвэр, бохир ус	4,310,191.00	4,193,255.00
Хангамж, бараа материалын зардал	20,805,008.17	19,314,397.09
Бичиг хэрэг	4,822,300.00	9,300,230.00
Тээвэр, шатахуун	8,738,360.00	5,516,000.00

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,353,748.17	3,407,567.09
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	890,600.00	1,090,600.00
Эд хогшил, урсгал засварын зардал	685,740.00	686,698.00
Урсгал засвар	685,740.00	686,698.00
Томилолт, зочны зардал	1,815,600.00	2,164,500.00
Дотоод албан томилолт	1,815,600.00	2,164,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,971,115.00	296,080,587.05
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,471,115.00	294,580,587.05
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	81,235,398.00	273,180,669.00
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.00	00.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	81,225,398.00	273,180,669.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,820,142.13	33,144,411.83
Бусад урсгал шилжүүлэг	4,329,000.00	00.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,329,000.00	00.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,491,142.13	33,144,411.83
Төвлөрүүлэх шилжүүлэг	33,491,142.13	33,144,411.83
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-10,000.00</u>	<u>00.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-10,000.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,000.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	7,661,369,919.23	7,661,369,919.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,412,000.00	2,412,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	7,663,781,919.23	7,663,781,919.23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-546,752,326.37	-546,752,326.37
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	7,117,029,592.86	7,117,029,592.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	7,117,029,592.86	7,117,029,592.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	17,986,956.29	00.00	17,986,956.29
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-	-
			3,717,222,750.16	3,717,222,750.16
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	17,986,956.29	3,399,806,842.70	3,417,793,798.99

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	299,744,600.00	289,591,799.17	10,512,800.83	96.6
УРСГАЛ ЗАРДАЛ	299,744,600.00	289,591,799.17	10,512,800.83	96.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,744,600.00	289,591,799.17	10,512,800.83	96.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,311,700.00	200,885,115.03	6,426,584.97	96.9
Үндсэн цалин	179,530,300.00	173,103,715.03	6,426,584.97	96.4
Нэмэгдэл	10,629,700.00	10,629,700.00		100
Унаа хоолны хөнгөлөлт	17,151,700.00	17,151,700.00		100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,877,400.00	24,877,400.00		100
Тэтгэврийн даатгал	16,584,900.00	16,584,900.00		100
Тэтгэмжийн даатгал	2,073,200.00	2,073,200.00		100
ҮОМШӨ-ний даатгал	1,658,500.00	1,658,500.00		100
Ажилгүйдлийн даатгал	414,600.00	414,600.00		100
Эрүүл мэндийн даатгал	4,146,200.00	4,146,200.00		100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,576,400.00	34,893,433.00	682,967.00	98.1
Гэрэл, цахилгаан	19,921,800.00	19,578,845.00	342,955.00	98.3
Түлш, халаалт	11,179,800.00	11,121,333.00	58,467.00	99.5
Цэвэр, бохир ус	4,474,800.00	4,193,255.00	281,545.00	93.7
Хангамж, бараа материалын зардал	11,427,000.00	11,255,397.09	171,602.92	98.5
Бичиг хэрэг	1,538,300.00	1,538,230.00	70.00	100
Тээвэр, шатахуун	5,219,000.00	5,219,000.00		100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,579,100.00	3,407,567.09	171,532.91	95.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,090,600.00	1,090,600.00		100
Эд хогшил, урсгал засварын зардал	686,700.00	686,698.00	2.00	100
Урсгал засвар	686,700.00	686,698.00	2.00	100
Томилолт, зочны зардал	1,874,500.00	1,874,500.00		100
Дотоод албан томилолт	1,874,500.00	1,874,500.00		100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,093,500.00	4,225,927.05	2,867,572.95	59.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,346,000.00	2,725,927.05	2,620,072.95	51
Аудит, баталгаажуулалт,	1,500,000.00	1,500,000.00		100

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

зэрэглэл тогтоох				
Даатгалын үйлчилгээ	118,800.00	00.00	118,800.00	
Тээврийн хэрэгслийн татвар	69,300.00	00.00	69,300.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	00.00	59,400.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	10,897,400.00	10,893,329.00	4,071.00	100
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,897,400.00	10,893,329.00	4,071.00	100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00		
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00		
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	299,744,600.00	299,744,600.00		100
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	299,744,600.00	299,744,600.00		100
Улсын төсвөөс санхүүжих	299,744,600.00	299,744,600.00		100
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	24.00		96
Удирдах ажилтан	2.00	2.00		100
Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00		100
Үйлчлэх ажилтан	5.00	4.00		80
Гэрээт ажилтан	00.00	00.00		

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв			САГ-2019/369/СТА-ТШЗ
				Мянган төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Байгууллага өөрийн хөрөнгийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлээгүй байгаа нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн дүрмийн 5.1-д "Үйлдвэрийн газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, үүрэг хүлээнэ" гэж заасны дагуу эрх эдэлж, үүрэг хүлээх нөхцөл бүрдэхгүй байна.	3,417,793.8	Зөвлөмж		
Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь "Монголын байгаль орчны иргэний зөвлөл", "Байгаль, зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг" төрийн бус байгууллагуудад өөрийн байрыг түрээслэхдээ дараах зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд: • Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ын дагуу гэрээ байгуулаагүй. • Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт түрээсийн орлого төвлөрүүлээгүй.	0	Зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Номин О.Баярцэцэг
Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийх явцад 5-6 жилийн өмнө бүртгэлд авсан ашиглагдахгүй байгаа 6,168.3 мянган төгрөгийн үнэлгээтэй кафетерийн зориулалт бүхий үндсэн хөрөнгүүд байна.	6,168.3	Зөвлөмж		
Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь 5,988.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийсэн.	5,988.0	Зөвлөмж		
Нийт дүн	3,429,950.1			

